



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 517

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 35 нэрийн, нийт 6,942,171,627.00 (зургаан тэрбум есөн зуун дөчин хоёр сая нэг зуун далан нэгэн мянга зургаан зуун хорин долоо) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хөвсгөл, Баянхонгор аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөвсгөл, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, хавсралтад заасан Хөвсгөл, Баянхонгор аймгийн орон нутгийн өмчит байгууллагад эзэмшүүлэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002413
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн
517 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦ)-ААР БИЙ БОЛСОН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлд тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх байгууллага
						Огноо	Дугаар	
Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт								
1	Хүнсний ногооны зоорины барилга 500тн /Хөвсгөл, Мөрөн/	Хүнсний ногооны зоорины барилга /500тн, зоорьгүй/	м.кв	588	965,983,672.00	2023.11.06	ББКД-67-66/23	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар
2		Гадна цахилгааны шугам /0.4квт дэд станц/	м	165	87,733,784.00			
3		Хөргүүр /DJ-35.9/210, 200ммГц0, 4х1100 Вт, 210м2 хөргөх/	ш	6	64,680,000.00			
4		Хөргөлтийн мотор /ZBSW21KQE -PFJ-558, 20600Вт, 380V/	ш	6	48,920,000.00			
5		Сэнс /380V, 0.12кВТ/	ш	2	15,382,544.00			
Дүн					1,182,700,000.00			
Баянхонгор аймгийн орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт								
6	Ингэний сүүний үйлдвэрийн барилга /Баянхонгор/	Барилга /1 давхар, зоорьгүй, 456м2, 1740 м3 эзэлхүүн/	м.кв	456	1,287,662,148.00	2022.10.21	2022/21	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
7		Гадна тохижилт	м.кв	50	32,751,677.00	2022.10.21	2022/21	
8		Сүү хүлээн авах сав /3тн, 380В/50Hz, 3.2 кВт, холигч 1.1кВт/	ш	1	45,000,000.00	2022.10.21	2022/21	
9		Шугамын шүүлтүүр /2 тн/ц, хэмжээ 500х180х650, жин 45 кг/	ш	1	5,300,000.00	2022.10.21	2022/21	
10		Сүүний насос /2 тн/ц/	ш	6	17,400,000.00	2022.10.21	2022/21	
11		Түүхий сүүний танк /1 тн, жин 1000 кг/	ш	3	54,000,000.00	2022.10.21	2022/21	
12		Цөцгий ялгах сеператор /1тн/ц, 220/380В, 11 кВт, жин 260 кг/	ш	1	36,000,000.00	2022.10.21	2022/21	
13		Жигдрүүлэгч /1 тн/ц, 220/380В, 7.5 кВт, 25 МПа, жин 280 кг/	ш	1	45,200,000.00	2022.10.21	2022/21	
14		Цөцгийн танк /Эзэлхүүн 200л, 220/380В, 2.5 кВт, жин 480 кг/	ш	1	19,500,000.00	2022.10.21	2022/21	
15		Сүүний үнэр зайлуулагч /1 тн/ц, 220/380В, 2.5 кВт/	ш	1	27,000,000.00	2022.10.21	2022/21	
16		Ариутгасан сүүний танк /Эзэлхүүн 0.5 тн, 220/380В, 2.5 кВт/	ш	1	15,500,000.00	2022.10.21	2022/21	

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлд тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх байгууллага
						Огноо	Дугаар	
17	Ингэний сүүний үйлдвэрийн барилга /Баянхонгор/	Тарагны танк /Эзэлхүүн 0.5 тн, материал 220/380В, 2.5 кВт/	ш	1	18,000,000.00	2022.10.21	2022/21	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
18		Завсарын танк /Эзэлхүүн 0.3 тн, 220/380В, 2.2 кВт/	ш	3	15,900,000.00	2022.10.21	2022/21	
19		CIP угаалгын станц /иж бүрдэл, 1.5 тн, 220/380В, 3.5 кВт/	ком	1	140,827,000.00	2022.10.21	2022/21	
20		Вакуум өтгөрүүлэгч /(0.7Мпа)500 кг/ц, 380В, 2 кВт, жин 450 кг/	ком	1	430,000,000.00	2022.10.21	2022/21	
21		Хөргөх камер (2-80С)>60 м3	ш	2	178,285,380.00	2022.10.21	2022/21	
22		Сүү тоосруулан хатаагч /иж бүрдэл/	ком	1	623,799,100.00	2022.10.21	2022/21	
23		Ажлын ширээ	ш	2	2,200,000.00	2022.10.21	2022/21	
24		Уур үүсгэгч иж бүрдэл (0.7Мпа) 500 кг/ц/	ком	1	460,000,000.00	2022.10.21	2022/21	
25		Агаараар ариутгах дамжих өрөө /Air shower-SUS 304/	ш	1	28,500,000.00	2022.10.21	2022/21	
26		Ажлын гутал хатаах ариутгах төхөөрөмж	ш	1	4,100,000.00	2022.10.21	2022/21	
27		Хуурай сүү жижиглэн савлах төхөөрөмж /15-45уут/мин, савлах хэмжээ 300-1500 гр/	ш	1	39,000,000.00	2022.10.21	2022/21	
28		Лонход, лаазанд савлах төхөөрөмж	ш	1	65,000,000.00	2022.10.21	2022/21	
29		Хийн компрессорын систем	ком	2	30,000,000.00	2022.10.21	2022/21	
30		Лабораторийн хөргөгч /700*830*2050, 550л/	ш	1	9,400,000.00	2022.10.21	2022/21	
31		Нержин хоолой	ком	1	66,922,000.00	2022.10.21	2022/21	
32		Уур, сүүний шугам хоолой /225 м/	ком	1	117,900,000.00	2022.10.21	2022/21	
33		Ялтаст ариутгагч /SUS 304/	ш	1	33,000,000.00	2022.10.21	2022/21	
	Дүн				3,848,147,305.00			
34	Өвлийн хүлэмжийн барилга	Өвлийн хүлэмжийн барилга /2	м.кв	1000	1,663,446,322.00	2023.12.06	2023/29	
35	Усалгааны систем /Баянхонгор/	Усалгааны систем /100м2, 50мм-500м урт/	ком	2	247,878,000.00	2023.12.06	2023/29	
	Дүн				1,911,324,322.00			
	НИЙТ ДҮН				6,942,171,627.00 (зургаан тэрбум есөн зуун дөчин хоёр сая нэг зуун далан нэгэн мянга зургаан зуун хорин долоо)			